# Анагаахын суурь боловсролын дамжаанд суралцагчид хүний их эмч мэргэжлийн цогц чадамжид өгөх сэтгэл ханамж

*М.Өсөхбаяр[1], Н.Эрдэнэхүү[2], Я.Энхтөр[1], Б.Оюунгоо[1]*
*[1] Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль*
*[2]Хавдар судлалын үндэсний төв*
*Цахим шуудан: usukhbayar@mnums.edu.mn Утас: 99080154*

**Түлхүүр үг:**
Оюутан
Хүрэх үр дүн,
Үнэлгээ

**Товч утга:**

**Үндэслэл:** Хүний их эмчийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээнд ихэвчлэн анагаахын суурь боловсролын дамжааны дараах дөрвөн жилийн сургалтад сурч буй суралцагчдыг илүү төлвөрч үнэлгээ хийдэг. Гэхдээ анагаахын суурь боловсролын дамжаа нь хүний их эмч бэлтгэх сургалтын нэгээхэн хэсэг бөгөөд бид энэхүү судалгаагаараа хүний их эмчийн хүрэх үр дүн болох цогц чадамжийг анагаахын суурь боловсролын дамжаанд суралцаж буй суралцагчдаар үнэлүүллээ. Зорилго: АШУҮИС–ийн АУС–ийг “Хүний их эмч” мэргэжлийн цогц чадамжид өгөх анагаахын суурь боловсролын дамжааны суралцагчдын сэтгэл ханамжийг судлах. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвар ашиглан 2023 оны 6-р сараас 2024 оны 3-р сарын хооронд АШУҮИС–ийн АСБД –нд суралцаж буй нийт 633 суралцагчдаас судалгааг авсан. Судалгаанд хамрагдсан суралцагчдаас хүн амын ерөнхий үзүүлэлтүүд (5 асуулт), ерөнхий сэтгэл ханамж (17 асуулт), цогц чадамжийн чиглэлээр (18 асуулт) гэсэн чиглэлээр нийт 40 асуулт бүхий асуумжийг цахим хэлбэрээр судалгааг авсан. Судалгааны мэдээллийг IMB SPSS Statistics 17 програмыг ашиглан боловсруулж, үр дүнд дескриптив болон нарийвчилсан статистик шинжилгээ хийсэн. Судалгаанд хамрагдагчдын сэтгэл ханамжийн түвшинг 5 оноо бүхий Ликертийн хэмжүүрээр үнэлэн, судалгааны үр дүнг SPSS-19.0 программыг ашиглан бүх үр дүнгийн хувьд статистик үнэн магадлалыг 95% хувийн ($p<0.05$) магадлалаар баталгаажуулсан болно. **Үр дүн:** Бидний судалгаанд хамрагдсан нийт 633 суралцагчдын 20.9% (132) нь эрэгтэй, 79.1% (501) нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийг насны байдлаар нь авч үзвэл дундаж нас нь 20.0±1.8 байлаа. 1-р дамжаанд 47.9% (303), 2-р дамжаанд 52.9% (330) суралцаж байсан. Хугацаандаа суралцаж байсан 89.1% (564), улиран суралцсан буюу жилийн чөлөө авч байсан 10.9% (69) суралцагч байсан. Нийт суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 3.64±0.84, үүнээс хамгийн өндөр нь 1-р дамжааны суралцагч нар харилцагч байх чадвар сайн эзэмшиж байгаа гэж 3.87±0.81, хамгийн бага нь 2-р дамжааны суралцагч зохион байгуулагч чадвар сайн эзэмшиж байгаа гэж 3.30±0.84 гэж үнэлсэн байна. Суралцаж буй суралцагчдын сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлтийг хүйс хоорондын ялгаа байгаа эсэхийг судлахад зөвлөгч байх чадвар сайн эзэмшиж байгаа гэж эрэгтэй суралцагч - 3.51±0.91, эмэгтэй суралцагч - 3.68±0.83 гэж үнэлсэн статистик үнэн магадлалтай байна. ($p<0.05$) **Дүгнэлт:** “Хүний их эмч” цогц чадамжид өгсөн анагаахын суурь боловсролын дамжааны суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 3.64±0.84 үнэлсэн нь дундажаас дээгүүр байна. Суралцагчдын цогц чадамжийн өгөх сэтгэл ханамжийн түвшин суралцаж буй дамжаа, хүйс, хугацаандаа суралцаж байгаа зэргээс хамаарч харилцан адилгүй байна.

**Үндэслэл:** Мэдлэгт суурилсан нийгмийн ажлын байрны эрэлт хэрэгцээтэй уялдан дэлхийн улс орнуудын дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа чиг хандлага өөрчлөгдөн шинэчлэгдэж байна.[1] 1990-ээд оноос эхлэн “Үр Дүнд Суурилсан Боловсрол (ҮДСБ)” гэж нэрлэдэг сургалтын онол, арга зүйг дэлхийн ихэнх улс орнууд дээд боловсролын системдээ өргөн ашиглах болжээ.[2] Хүний их эмчийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээнд ихэвчлэн анагаахын суурь боловсролын дамжааны дараах дөрвөн жилийн сургалтанд сурч буй суралцагчдыг илүү төлвөрч үнэлгээ хийдэг. Монгол Улсад анх удаа АШУҮИС нь эрүүл мэндийн мэргэжилтний 13-н мэргэжлийн “Мэргэжилтний цогц чадамж”-ийг 2015 онд боловсруулан сургалтын хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна. Хүний их эмчийн цогц чадамжийг боловсруулахдаа Канад улсын төгсөлтийн дараах сургалт, магадлан итгэмжлэлийн стандартуудыг хариуцсан Канадын Эмч, Мэс Засалчдын Эзэн Хааны Коллежийн шийдвэрлэсэн. 2001 онд бүтээгдэж 2005 оноос албан ёсоор “Цэцгийн дэлбээ” хэлбэрээр хэрэглэж байгаа CanMEDS-ийн загварыг тулгуур болгон боловсруулсан.[3]

Хүний их эмчийн цогц чадамжийг боловсруулан мөрдөж эхэлснээс хойш цогц чадамжийг судалсан судалгаа одоогоор хомс байна. Анагаахын суурь боловсролын дамжаа нь хүний их эмч бэлтгэх сургалтын нэгээхэн хэсэг бөгөөд бид энэхүү судалгаагаараа хүний их эмчийн хүрэх үр дүн болох цогц чадамжийг анагаахын суурь боловсролын дамжаанд суралцаж буй суралцагдчаар үнэлүүллээ.

**Зорилго:** АШУҮИС-ийн анагаахын суурь боловсролын дамжаанд суралцагчид “Хүний их эмч” мэргэжлийн цогц чадамжинд өгөх сэтгэл ханамжийг судлах

**Зорилт:**

1. Анагаахын суурь боловсролын дамжааны суралцагдын цогц чадамжийн сэтгэл ханамжийг үнэлэх
2. Суралцагчдын цогц чадамжинд өгөх сэтгэл ханамжийн түвшин хооронд хамаарлыг судлах


Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар 2023 оны 6-р сараас 2024 оны 3-р сарын хооронд АШУҮИС–ийн АСБД–нд суралцаж буй нийт 633 суралцагчдаар үнэлүүлсэн.

Судалгаанд хамрагдсан суралцагчдаас хүн амын ерөнхий үзүүлэлтүүд (5 асуулт), ерөнхий сэтгэл ханамж (17 асуулт), цогц чадамжийн чиглэлээр (18 асуулт) гэсэн нийт 40 асуулт бүхий асуумжийн хуудсаар судалгааг авсан. Тус цогц чадамжийн чиглэлийн асуумжийг Хүснэгт 1-т харуулсан байдлаар 6 бүлэг, 18 дэд бүлгээр томъёолон болосвруулан үнэлүүлсэн.

Судалгаанд хамрагдагчдын сэтгэл ханамжийн түвшинг 5 оноо бүхий Ликертийн хэмжүүрээр үнэлсэн. (5 – санал бүрэн нийлнэ, 4 – ихэнхдээ санал нийлнэ, 3 – дунд зэрэг нийлнэ, 2 – ихэнхдээ санал нийлэхгүй, 1 – огт санал нийлэхгүй) Судалгааны мэдээллийг IMB SPSS Statistics 26 програмыг ашиглан суралцагчдын үр дүнгийн хувьд холбогдох дескриптив үзүүлэлтүүдийг гаргасан бөгөөд суралцагчдын сэтгэл ханамжийн ялгаатай байдлыг үл хамааралт хоёр түүврийн T тестээр боловсруулж, (Independent-Sample T Test ) суралцагчдын дамжаа ахихын хэрээр сэтгэл ханамж хэрхэн өөрчлөгдөж байгааг нөлөөллийн хэмжигдэхүүнээр тооцон (Cohen`s effect size) судалсан ба судалгааны үр дүнгийн хувьд статистик үнэн магадлалыг 95% хувийн ($p<0.05$) магадлалаар баталгаажуулсан болно.

**Үр дүн:** Бидний судалгаанд хамрагдсан нийт 633 суралцагчдын 20.9% (132) нь эрэгтэй, 79.1% (501) нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийг насны байдлаар нь авч үзвэл дундаж нас нь 20.0± 1.8 байлаа. 1-р дамжаанд 47.9% (303), 2-р дамжаанд 52.9% (330) суралцаж байсан. Хугацаандаа суралцаж байсан 89.1% (564), улиран суралцсан буюу жилийн чөлөө авч байсан 10.9% (69) суралцач байв. (Зураг 1)

Нийт суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин - 3.64±0.84 байснаас хамгийн өндөр сэтгэл ханамжийн түвшин нь 1-р дамжааны суралцагч нар харилцагч байх чадвар сайн эзэмшиж байгаа гэж 3.87±0.81, хамгийн бага сэтгэл ханамжийн түвшин нь 2-р дамжааны суралцагч зохион байгуулагч чадвар сайн эзэмшиж байгаа гэж 3.30±0.84 үнэлсэн байна.




**Зураг 1. Суралцагчдын хүйс, дамжаа, шилжилт хөдөлгөөний эзлэх хувь**

Суралцагчдын хүйс, шилжилт хөдөлгөөн, дамжаа зэрэг номинал үзүүлэлтийн хоорондын ялгааг судлахад зөвлөгч байх чадвар сайн эзэмшиж байгаа гэж эрэгтэй суралцагч 3.51±0.91, эмэгтэй суралцагч 3.68±0.83 үнэлсэн байгаа нь статистик үнэн магадлалтай байна. ($p<0.05$) Шилжилт хөдөлгөөнд сэтгэл ханамжийн дундаж ялгаа байгаа эсэхийг судлахад харилцагч байх чадвар сайн эзэмшиж байгаа гэж хугацаандаа суралцаж байгаа суралцагч - 3.70±0.84, жилийн чөлөөнөөс суралцсан суралцагч - 3.43±0.82 гэж тус тус үнэлсэн байгаа нь статистик үнэн магадлалтай байсан. ($p>0.05$) Суралцагчдын дамжаа хооронд сэтгэл ханамжийн дундаж утганд ялгаа байгаа эсэхийг судлан тодорхойлов. (Хүснэгт 2). 2-р дамжааны суралцагчдаас 1-р дамжааны суралцагчид илүү сэтгэл ханамжтай байгаа нь статистик үнэн магадлалтай байлаа.

**Хүснэгт 2. Суралцаж буй дамжаа хооронд харьцуулсан байдал**

| № | CanMEDS | 1-р дамжаа | 2-р дамжаа | P утга |
|---|---|---|---|---|
| 1 | Харилцагч байх | 3.87 (0.82) | 3.47 (0.81) | <.001 |
| 2 | Хамтрагч байх | 3.86 (0.89) | 3.41 (0.88) | <.001 |
| 3 | Зохион байгуулагч байх | 3.80 (0.82) | 3.30 (0.84) | <.001 |
| 4 | Эрүүл мэндийн зөвлөгч байх | 3.81 (0.82) | 3.50 (0.86) | <.001 |
| 5 | Тасралтгүй суралцагч байх | 3.79 (0.81) | 3.47 (0.82) | <.001 |
| 6 | Мэргэжилтэн байх | 3.83 (0.83) | 3.51 (0.84) | <.001 |

Судалгааны цогц чадамжийн үзүүлэлт бүрийн дундаж утгуудыг эрэмбэлэх байдлаар үр дүн гаргасныг хүснэгт 3-аар харуулав. Харилцагч байхын 3 дэд бүлэг болох “Үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг бичгээр болон амаар үнэн зөв дамжуулах чадварууд” болон Мэргэжилтэн байхын 2 дэд бүлэг болон “Өдөр тутмын ажилдаа анагаах ухаан, хууль зүй, мэргэжлийн хэм хэмжээг хүндэтгэн, ёс зүйн хариуцлагаа ухамсарлан ажиллах чадварууд” тус тус 1,2 дамжааны суралцагч ижил өндөр сэтгэл ханамжаар үнэлсэн байна.

Зохион байгуулагч байхын 4 дэд болох “Салбар хоорондын багийн үйл ажиллагаанд үр дүнтэйгээр оролцох чадварууд”, зохион байгуулагч байхын 1 дэд бүлэг болох “Өөрийн сургалтын хэрэгцээ, хувийн амьдрал, эрүүл мэндийн байдалдаа цаг хугацаа боломжит нөөцийг үр дүнтэйгээр ашиглах чадварууд” тус тус 1,2 дамжааны суралцагч ижил бага сэтгэл ханамжаар үнэлсэн байна.

**Хүснэгт 3. Цогц чадамжийн дамжаа бүрээр үнэлсэн сэтгэл ханамжийн эрэмбэлэлт**

| CanMEDS | 1-р дамжаа | **Эрэмбэ** | 2-р дамжаа | **Эрэмбэ** |
|---|---|---|---|---|
| 1.Харилцагч байх-3 дэд бүлэг | 3.93 (0.88) | 1 | 3.57 (0.88) | 1 |
| 3.Зохион/бай байх-5 дэд бүлэг | 3.90 (0.94) | 2 | 3.39 (0.93) | 9 |
| 6.Мэргэжилтэн байх-2 дэд бүлэг | 3.90 (0.83) | 2 | 3.57 (0.91) | 1 |
| 1.Харилцагч байх-1 дэд бүлэг | 3.89 (0.95) | 3 | 3.49 (0.94) | 4 |
| 2.Хамтрагч байх-1 дэд бүлэг | 3.87 (0.95) | 4 | 3.45 (0.95) | 7 |
| 3.Зохион/бай байх-3 дэд бүлэг | 3.86 (0.90) | 5 | 3.35 (0.93) | 11 |
| 5.Тасралтгүй/сур байх-4 дэд бүлэг | 3.84 (0.90) | 6 | 3.56 (0.88) | 2 |
| 2.Хамтрагч байх-2 дэд бүлэг | 3.84 (0.93) | 6 | 3.37 (0.95) | 10 |
| 4.Э/м зөвлөгч байх-2 дэд бүлэг | 3.84 (0.88) | 6 | 3.54 (0.91) | 3 |
| 5.Тасралтгүй/сур байх-3 дэд бүлэг | 3.83 (0.88) | 7 | 3.46 (0.89) | 6 |
| 1.Харилцагч байх-2 дэд бүлэг | 3.79 (0.94) | 8 | 3.35 (0.89) | 11 |
| 4.Э/м зөвлөгч байх-1 дэд бүлэг | 3.79 (0.90) | 8 | 3.47 (0.91) | 3 |
| 5.Тасралтгүй/сур байх-2 дэд бүлэг | 3.77 (0.90) | 9 | 3.45 (0.95) | 7 |
| 3.Зохион/бай байх-2 дэд бүлэг | 3.76 (0.94) | 10 | 3.30 (0.97) | 12 |
| 6.Мэргэжилтэн байх-1 дэд бүлэг | 3.76 (0.92) | 10 | 3.45 (0.87) | 7 |
| 3.Зохион/бай байх-4 дэд бүлэг | 3.74 (0.93) | 11 | 3.25 (1.00) | 13 |
| 3.Зохион/бай байх-1 дэд бүлэг | 3.73 (0.97) | 12 | 3.22 (0.98) | 14 |
| 5.Тасралтгүй/сур байх-1 дэд бүлэг | 3.72 (0.97) | 13 | 3.40 (0.95) | 8 |

Суралцагчдын дамжаа ахих бүр цогц чадамжид өгөх сэтгэл ханамж нь өөрчлөгдөж байгаа дээр нөлөөллийн хэмжигдэхүүнээр тооцсоныг хүснэгт 4-өөр харуулав. Зохион байгуулагч байхын 3 дэд бүлэг болох “Эрүүл мэндийн байгууллагад үр ашигтай, бүтээлчээр ажиллах чадварууд” нь суралцагчдын дамжаа ахихад сэтгэл ханамжийн дундаж утга 0.51 буурч байгаад дунд зэрэг нөлөөлсөн байна. Тасралтгүй сурцагч байхын 4 дэд бүлэг болох “Шинэ мэдлэг бий болгох, түгээх, ашиглах чадварууд” нь суралцагчдын дамжаа ахихад сэтгэл хангамжийн дундаж утга 0.28 буурч байгаад бага зэрэг нөлөөлсөн байна. Дээрх үзүүлтүүд статистик үнэн магадлалтай байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

**Хүснэгт 4. Суралцагчдын дамжаа ахихад сэтгэл ханамжид нөлөөллийн хэмжигдэхүүнээр тооцоолсон дүн**

| CanMEDS | 1-р дамжаа | 2-р дамжаа | **Дундаж зөрүү** | P утга | Eta-squared η2 |
|---|---|---|---|---|---|
| 3.Зохион/бай байх-3 дэд бүлэг | 3.86 (0.90) | 3.35 (0.93) | -0.51 | 0.001 | 0.072 |
| 3.Зохион/бай байх-5 дэд бүлэг | 3.90 (0.94) | 3.39 (0.93) | -0.51 | 0.001 | 0.070 |
| 3.Зохион/бай байх-1 дэд бүлэг | 3.73 (0.97) | 3.22 (0.98) | -0.51 | 0.001 | 0.063 |
| 2.Хамтрагч байх-2 дэд бүлэг | 3.79 (0.94) | 3.35 (0.89) | -0.44 | 0.001 | 0.060 |
| 3.Зохион/бай байх-4 дэд бүлэг | 3.74 (0.93) | 3.25 (1.00 | -0.49 | 0.001 | 0.056 |
| 1.Харилцагч байх-2 дэд бүлэг | 3.79 (0.94) | 3.35 (0.89) | -0.44 | 0.001 | 0.054 |
| 3.Зохион/бай байх-2 дэд бүлэг | 3.76 (0.94) | 3.30 (0.97) | -0.46 | 0.001 | 0.051 |
| 2.Хамтрагч байх-1 дэд бүлэг | 3.87 (0.95) | 3.45 (0.95) | -0.42 | 0.001 | 0.050 |
| 1.Харилцагч байх-1 дэд бүлэг | 3.89 (0.95) | 3.49 (0.94) | -0.40 | 0.001 | 0.050 |
| 5.Тасралтгүй/сур байх-3 дэд бүлэг | 3.83 (0.88) | 3.46 (0.89) | -0.37 | 0.001 | 0.044 |
| 1.Харилцагч байх-3 дэд бүлэг | 3.93 (0.88) | 3.57 (0.88) | -0.36 | 0.001 | 0.044 |
| 4.Э/м зөвлөгч байх-1 дэд бүлэг | 3.79 (0.90) | 3.47 (0.91) | -0.32 | 0.001 | 0.034 |
| 6.Мэргэжилтэн байх-1 дэд бүлэг | 3.76 (0.92) | 3.45 (0.87) | -0.31 | 0.001 | 0.032 |
| 6.Мэргэжилтэн байх-2 дэд бүлэг | 3.90 (0.83) | 3.57 (0.91) | -0.33 | 0.001 | 0.031 |
| 5.Тасралтгүй/сур байх-2 дэд бүлэг | 3.79 (0.94) | 3.35 (0.89) | -0.44 | 0.001 | 0.029 |
| 4.Э/м зөвлөгч байх-2 дэд бүлэг | 3.84 (0.88) | 3.54 (0.91) | -0.30 | 0.001 | 0.027 |
| 5.Тасралтгүй/сур байх-1 дэд бүлэг | 3.72 (0.97) | 3.40 (0.95) | -0.32 | 0.001 | 0.026 |
| 5.Тасралтгүй/сур байх-4 дэд бүлэг | 3.84 (0.90) | 3.56 (0.88) | -0.28 | 0.001 | 0.026 |

**Хэлцэмж:** Энэ төрлийн судалгааны мэдээлэл одоогоор хомс байгаа юм. 2005 онд эрүүл мэндийн мэргэжилтэн өөрийгөө үнэлэх тухай судалгаа хийгдсэн байдаг. Тус судалгаанд өөрийгөө үнэлэх нь насан туршийн суралцахуйд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх мэдээлэл бидэнд мэдээлдэг тухай бичсэн байдаг.[4] Энэ нь бид энэ төрлийн өөрсдийнхөө эзэмшиж буй чадамжаа үнэлэх нь түүнийг сайжруулах гол үндсэн тулгуур мэдээллийн эх үүсгэвэр болох юм. Бид энэхүү судалгаагаар анагаахын суурь сургалтын хөтөлбөр нь тусдаа сургалтын хүрэх үр дүнтэй байж болох юм гэсэн дүгнэлт хүрч байгаа юм. Учир нь анагаахын суурь боловсролын дамжаа нь дан ганц хүний их эмчийн суурь хөтөлбөр биш бөгөөд олон хөтөлбөрийн суурь болдог тул дан ганц хүний их эмчийн цогц чадамжийг үнэлүүлэх нь учир дутагдалтай байж болох юм. 2008 онд хүний их эмчийн өөрийгөө үнэлсэн үнэлгээг ажиглах байдлаар ур чадварын хэмжигдэхүүнтэй харьцуулсан 725 эрдэм шинжилгээний өгүүлэлд судалгаа хийгдсэн байна. **Т**ус судалгаанд эмч нар өөрийгөө зөв үнэлэх нь хөндлөнгийн үнэлгээнээс илүү дутмаг байж болох талаар гаргаж ирсэн ба нэг ёсондоо өөрийгөө үнэлэх үнэлгээг өөр хэмжигдэхүүнээр баталгаажуулах ёстойг дурьдсан байна.[5] Иймээс бид энэхүү судалгааг цаашид бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийх замаар чанарын судалгааг хийж илүү олон зүйлсийг улам тодорхой болгох шаардлага тулгарч байна.

**Дүгнэлт:**

1. “Хүний их эмч” цогц чадамжид өгсөн анагаахын суурь боловсролын дамжааны суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 3.64±0.84 үнэлсэн нь дунджаас дээгүүр байна.

2. Суралцагчид дамжаа ахих бүрд цогц чадамжид өгөх сэтгэл ханамжийн түвшин буурч байгаа бөгөөд энэ нь дамжаа ахихад харилцан адилгүйгээр нөлөөлж байна.

**Ном зүй:**


1 *Transforming and scaling up health professionals’ education and training. World Health Organization guidelines. 2013.*

2 *Erdenekhuu.N, Uranchimeg.T . Assessment experience on program learning outcomes. Conference Paper. October 2018*

3 *Frank, JR. (Ed). 2005. The CanMEDS 2005 physician competency framework.*

4 *Eva KW, Regehr G. Self-assessment in the health professions: A reformulation and research agenda. Acad Med. 2005;80(10 suppl):S46–S54*

5 *Davis DA, Mazmanian PE, Fordis M, Van Harrison R, Thorpe KE, Perrier L. Accuracy of physician self-assessment compared with observed measures of competence: A systematic review. JAMA. 2006;296:1094–1102*

# A satisfaction survey of competency framework for “Medical students” curriculum in Mongolia

***Usukhbayar M[1], Erdenekhuu N[2], Enkhtur Ya[1], Oyungoo B[1]***
*[1]School of Medicine, Mongolian National University of Medical Sciences*
*[2]National cancer center of mongolia*
*Email:usukhbayar@mnums.edu.mn, Tel: 99080154*

**Keywords:**
Students
Survey
Research Outcome

**Background:** Competency-based health professions education is widely implemented as the framework for preparing health professionals for practice. Competency-based health professions education is inclusive of competency or practice standards that articulate the knowledge, skills, attitudes, and capabilities of a profession; the curriculum and assessment that supports achievement and measurement against these standards, and accreditation policies and procedures. Competency-based assessment in the workplace is a critical part of competency-based education. Recently, Mongolian National University of Medical Sciences assessment include senior year students curriculum of framework competency who enrolled after four-year clinical training program. One of the indicators of the quality of educational services in higher education institutions is student framework satisfaction. Therefore, freshman student’s framework competency-based assessment satisfaction is necessary. **Aim:** To assess premedical student’s competency framework satisfaction in Mongolian National University of Medical Sciences **Materials and methods:** The study was conducted using an analytic survey design between June, 2023 to March, 2024. In the survey, Six hundred thirty three freshman medical students completed demographic (5 questionaire), satisfaction (17 questionaire), and competency framework (18 questionaire) overall 40 questionaire. All variables were described using numbers (n) and percentages (%). All statistical procedures were performed using IBM SPSS Statistics for Windows, version 19.0 (IBM Corp., Armonk, NY, USA); *P*-values of less than 0.05 were considered to indicate statistical significance. The Likert rating score of the overall satisfaction of premedical students. **Results:** Total of 633 premedical students were included in the study, 20.9% (132) were male and 79.1% (501) were female, with a mean age of 20.0 ± 1.8. 47.9% (303) studied in the freshman year, and 52.9% (330) studied in the second grade. There were 89.1% (564) students who were studying full-time, and 10.9% (69) who were taking a year off. The overall level of satisfaction of all students is 3.64±0.84, the highest of which is 3.87±0.81, and the lowest is 3.30±0.84, mean value of this indicator was 3.30±0.84 was evaluated. When studying whether there is a difference between genders in the average level of satisfaction of the students, it is statistically probable that male students - 3.51±0.91, female students - 3.68±0.83, that they have mastered the ability to be a mentor well. ($p<0.05$) **Conclusion:** The satisfaction of premedical student’s basic medical education students given to the competency framework of “Medical doctor” 2-4 curriculum was rated 3.64±0.84, which was above average. Premedical students’ satisfaction with framework competencies varies depending on the course which they study, gender, and the full and part-time study plan.